



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 04 сарын 17 өдөр

Дугаар А/150

Улаанбаатар хот

Аргачилсан заавар батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5, Эрүүл ахуйн тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 16.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Жижиг суурин газрын ус хангамжид нэвтрүүлэх “Хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, эрсдэлийн үнэлгээ хийх аргачилсан заавар”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан энэхүү тушаалаар баталсан аргачилсан зааврын дагуу хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан, хэрэгжүүлж ажиллахыг сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Өмчийн бүх төрөл, хэлбэрийн Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төвд ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхийг тухайн шатны Засаг дарга, байгууллага, хуулийн этгээдийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

4. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх санхүүжилтийг холбогдох орон нутгийн хөгжлийг дэмжих сан, төсөл хөтөлбөр, жил бүрийн орон нутгийн болон өөрийн байгууллагын төсөвт тусгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг нарт даалгасугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 512 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080538

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 2-р сарын 17-ны өдрийн
А/150 дугаар тушаалын хавсралт

ЖИЖИГ СУУРИН ГАЗРЫН УС ХАНГАМЖИД НЭВТРҮҮЛЭХ ХҮН АМЫН УНДНЫ УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ХИЙХ АРГАЧИЛСАН ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Жижиг суурин газрын ус хангамжтай сум, дүүрэг, баг, хороо, байгууллага (ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дүүргийн нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв) нь “Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө” /цаашид “төлөвлөгөө” гэх/-г боловсруулна.

1.2 Жижиг суурин газрын ус хангамжинд нэвтрүүлэх хүн амын ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулахад Эрүүл мэнд, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны А/149/78 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ыг мөрдлөг болгоно.

Хоёр. Төлөвлөгөө боловсруулахад баримтлах зарчим

2.1 Төлөвлөгөөг боловсруулахдаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан “Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг улсын түвшинд хэрэгжүүлэх хөтөч”, “Жижиг суурин газрын ус хангамжид усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулах нь”, “Жижиг суурингийн ус хангамжийн тандалт, хяналт” зэрэг гарын авлага, зөвлөмжийг ашиглана:

2.1.1. Төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхдээ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас боловсруулсан зөвлөмжийн дагуу 6 алхамыг;

2.1.2. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд үүсч болох эрсдэл, сайжруулах арга зам, шаардагдах хөрөнгө, хөрөнгийн эх үүсвэр, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах албан тушаалтныг тодорхой тусгана. Шаардлагатай гэж үзвэл төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

Гурав. Төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажил

Олон нийтийн оролцоог хангах, баг бүрдүүлэх

3.1 Сум, дүүрэг, баг, хороо, байгууллага нь төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрт оршин сууж буй иргэдийн саналыг авсан байна.

3.2 Усны эх үүсвэрийн онцлог, хүн амын үйлчлэх хүрээнээс хамаарч төлөвлөгөө боловсруулах баг нь сум, дүүрэг, баг, хороо, байгууллагын түвшинд эсвэл ус хангамжийн тогтолцооноос хамаарч бие даасан хэд хэдэн баг /цаашид “баг” гэх/-тай байж болно.

3.3 Сум, дүүрэгт багийн ахлагчаар тухайн шатны сум, дүүргийн Засаг дарга, нарийн бичгийн даргаар суманд байгаль орчны хяналтын улсын байцаагч, дүүрэгт нийгмийн хөгжлийн хэлтсийн асуудал хариуцсан холбогдох албан тушаалтныг тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын шийдвэрээр томилно.

3.4 Баг, хороонд багийн ахлагчаар тухайн шатны баг, хорооны Засаг дарга, нарийн бичгийн даргаар баг, хорооны нийгмийн асуудал хариуцсан холбогдох албан тушаалтныг тухайн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр томилно.

3.5 Байгууллагад багийн ахлагчаар тухайн байгууллагын захирал, дарга, нарийн бичгийн даргаар асуудал хариуцсан холбогдох албан тушаалтныг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга томилно.

3.6 Баг нь 7-оос доошгүй гишүүнтэй байна. Багийн гишүүдийн харъяалагдах байгууллага, албан тушаал болон гүйцэтгэх үүрэг, холбоо барих утас, хаяг зэргийг багийн ахлагч бүртгэж, баталгаажуулсан байна /Алхам 1 буюу Загвар 1/.

Төлөвлөгөө боловсруулах үйл явц

3.7 Төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх тайланг баг, хороо нь харъяа сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт, сум нь аймгийн Засаг даргын тамгын газарт, дүүрэг, цэцэрлэг, сургууль, эмнэлэг нь дүүргийн Засаг даргын тамгын газарт, дүүргийн Засаг дарга нь Нийслэлийн Засаг даргын тамгын газарт жилд нэг удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр хүргүүлнэ.

3.8 Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар нь төлөвлөгөөний хэрэгжилт, явц, үр дүнгийн талаарх тайланг Эрүүл мэнд, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны А/149/78 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар"-ын 3.2.7-д заасны дагуу жилд 1 удаа тайлагнана.

Дөрөв. Тогтолцооны үнэлгээ

4.1 Төлөвлөгөө боловсруулахдаа ус хангамжийн тогтолцоог газар дээр нь очиж үзэн, усны эх үүсвэр, газар зүйн онцлогийг харуулсан газрын зураг, ус хангамжийн тогтолцооны зураглалыг гаргана /Алхам 2 буюу Загвар 2/.

4.2 Ус хангамжийн тогтолцооны зураглалыг гаргахдаа ерөнхий мэдээллээс гадна ус хангамжийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болох ус олборлох, боловсруулах, нөөцлөх, түгээх, цуглуулах, хэрэглэх үе шат болон усны чанарын талаарх мэдээллийг оруулна /Алхам 2 буюу Загвар 3/.

4.3 Ус хангамжийн тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд аюулт хүчин зүйл, үзэгдэл, эрсдэлийг үнэлэн /Алхам 3 буюу Загвар 4/ эрэмбэлж, сайжруулах арга замыг тодорхойлно /Алхам 3 буюу Загвар 5/.

4.4 Эрсдэлийг бууруулах, арилгахад чиглэсэн сайжруулах төлөвлөгөөг боловсруулахдаа хамтран ажиллах байгууллага, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилтийг тусгана /Алхам 4 буюу Загвар 6/.

Тав. Үйл ажиллагааны хяналт - шинжилгээ

5.1 Төлөвлөгөөний үр дүнг баталгаажуулахын тулд хяналт-шинжилгээний хөтөлбөрийг боловсруулна /Алхам 5 буюу Загвар 7/.

5.2 Ундны усны чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт - шинжилгээг хангагч байгууллага, хөндлөнгийн хяналт - шинжилгээг хяналтын байгууллага батлагдсан стандарт, зааврын дагуу хийнэ.

5.3 Төлөвлөгөөнд хөндлөнгийн болон дотоод аудитыг батлагдсан зааврын дагуу хийнэ.

5.4 Усны чанар, аюулгүй байдлын талаарх мэдлэг болон хангагч байгууллагын үйлчилгээнд өгч буй сэтгэл ханамжийн судалгааг жилд нэг удаа асуулгаар авч үнэлэн, холбогдох саналыг төлөвлөгөөнд тусгана /Алхам 5 буюу Загвар 8/.

Зургаа. Удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагаа

6.1 Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь аймаг, дүүргийн багийн гишүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

6.2 Аймгийн баг нь сум, хороо, баг, байгууллагыг, дүүргийн баг нь хороо, баг, байгууллагын багийн гишүүдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллана.

6.3. Ус хангамжийн тогтолцооны үйл ажиллагааны алхам бүрийн хэрэгжилтийг баримтжуулна.

6.4 Үйл ажиллагааны хэвийн болон ноцтой нөхцөл байдал үүссэн болон үүсч болзошгүй үед багийн ажиллах төлөвлөгөөг тусгайлан боловсруулж, цаасан болон цахим хэлбэрээр баримтжуулж, хадгална.

6.5 Төлөвлөгөөний хэрэгжилттэй холбоотой бүхий л асуудлыг тусгасан дэмжих хөтөлбөрийг боловсруулах, төлөвлөгөөний хэрэгжилтэд тойм үнэлгээ хийж, холбогдох асуудлыг шийдвэрлүүлнэ /Алхам 6 буюу Загвар 9/.

----oOo-----

АЛХАМ 1. УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ
БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, АЖИЛ ҮҮРГИЙН ХУВААРЬ

... СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

... оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Баг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2, Хот суурины усан хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас ТОГТООХ нь:

1.Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, багийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавихыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд даалгасугай.

ДАРГА

Засаг даргын ... оны ... дугаар
сарын ...-ны өдрийн дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах,
хэрэгжүүлэх багийн бүрэлдэхүүн

Багийн ахлагч: Сумын Засаг дарга

Нарийн бичгийн дарга: Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Гишүүд: Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч
Багийн Засаг дарга нар
Цаг уурын инженер
Хангагч байгууллага /тухайн сум ундны ус хариуцсан тусдаа
байгууллагатай тохиолдолд/
ЕБС-ийн захирал /өөрийн эх үүсвэртэй тохиолдолд/
Цэцэрлэгийн эрхлэгч /өөрийн эх үүсвэртэй тохиолдолд/
Төрийн бус байгууллага (зөвшилцсөнөөр)
Иргэдийн төлөөлөл (зөвшилцсөнөөр) г.м

Засаг даргын ... оны ... дугаар
сарын ...-ны өдрийн дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт


Усны аюулгүй байдлын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион
байгуулах багийн гишүүдийн ажил үүргийн хуваарь

№	Албан тушаал	Хариуцах ажил, үндсэн үүрэг	Хаяг, утас
1	Сумын засаг дарга, багийн ахлагч	УАБТ-г боловсруулж хэрэгжүүлэхэд УАБТ-ний багийг удирдан зохион байгуулж чиглүүлэх, багийн гишүүд ажил үүргийн хуваарийн дагуу үүргээ хэрхэн биелүүлж байгаад үнэлгээ өгөх, УАБТ-нд тойм үнэлгээ хийх, холбогдох асуудлыг шийдвэрлүүлэх	
2	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, багийн нарийн бичгийн дарга	Багийн гишүүдийн хурал, уулзалтыг тогтмол зохион байгуулах, мэргэжлийн хүмүүсээс зөвлөгөө туслалцаа авах, гадаад, дотоодын сургалтанд багийн гишүүдийг хамруулах, туршлага судлуулах, УАБТ-д хөндлөнгийн хяналт баталгаажуулалт хийх ажлыг зохион байгуулах УАБТ-нд тойм үнэлгээ хийх, Эрүүл мэнд, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны А/149/78 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Ус хангамж, ариун цэврийн байгууламжийн сүлжээнд эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын 3.2.7-д заасан жилд 1 удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр тайланг хүргүүлэх Ус хангамжтай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон шинээр гарсан стандартуудыг УАБТ-ний багт танилцуулах, мэдээллээр хангах Гадаргын уст цэгийн судалгааг гаргах, хяналт тавих	
3	Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч	Усны аюулгүй байдал, орчны эрүүл ахуй, иргэдэд чиглэсэн зөв зан үйлийг хэвшүүлэх чиглэлээр мэдээлэл, сургалт сурталчилгаа зохион байгуулах, УАБТ-ний хэрэгжилтийг зохион байгуулахад оролцох	
4	Багийн засаг дарга	УАБТ-г богино болон урт хугацаанд алсын хараатай боловсруулах, хэрэгжүүлэх, холбогдох бодлогын баримт бичгүүдийг сумын хөгжлийн бодлоготой	

		уялдуулах, санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэх	
4	Багийн засаг дарга /үргэлжлэл/	Ус хангамжид үүссэн болон үүсч болзошгүй эрсдэлийг арилгуулах арга хэмжээг УАБТ-нд тусгах, хэрэгжүүлэх Шинээр газар олгох, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ус хангамж, усан сан бүхий газар, худаг, усан сан болон холбогдох хууль, дүрэм журам, стандартын шаардлагыг хангах, стандарт зөрчигдсөн тохиолдолд усны эх үүсвэрийн газрыг чөлөөлөх	
5	Цаг уурын инженер	Усны бохирдлыг тогтоох, цаг уур, орчны мэдээллийг багт танилцуулах	
6	Хангагч байгууллага	“Ус түгээх байр” MNS ... :..., “Зөөврийн усны үйлчилгээ” MNS”, “Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS зэрэг стандартуудын шаардлагыг хангасан усаар сумын иргэдийг тасралтгүй, найдвартай хангах, усыг тогтмол шинжилгээнд хамруулах Ундны усыг олборлохоос хэрэглэгч хүртлэх тогтолцооны зураглал гаргах, ундны усыг бохирдуулж болох эрсдэлд үнэлгээ хийх, сайжруулах болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах Онцгой байдал болон гамшгийн үед сумын иргэдийг аюулгүй усаар хангах гамшиг, ноцтой байдлын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах Усны эх үүсвэрийн харуул, хамгаалалтыг өндөржүүлэх, гэмт халдлагаас хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	
7	ЕБС-ийн захирал	“Ус түгээх байр” MNS ... :..., “Зөөврийн усны үйлчилгээ” MNS”, “Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS зэрэг стандартуудын шаардлагыг хангасан усаар ЕБС-ийг тасралтгүй, найдвартай хангах, усыг тогтмол шинжилгээнд хамруулах Ундны усыг олборлохоос хэрэглэгч хүртлэх тогтолцооны зураглал гаргах, ундны усыг бохирдуулж болох эрсдэлд үнэлгээ хийх, сайжруулах болон үйл	

		<p>ажиллагааны төлөвлөгөө боловсруулах</p> <p>Онцгой байдал болон гамшгийн үед ЕБС-ийг аюулгүй усаар хангах гамшиг, ноцтой байдлын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах</p> <p>Усны эх үүсвэрийн харуул, хамгаалалтыг өндөржүүлэх, гэмт халдлагаас хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p>	
8	Цэцэрлэгийн эрхлэгч	<p>“Ус түгээх байр” MNS ... :..., “Зөөврийн усны үйлчилгээ” MNS:..., “Ундны усны эрүүл ахуйн шаардлага түүнд тавих хяналт MNS зэрэг стандартуудын шаардлагыг хангасан усаар цэцэрлэгийг тасралтгүй, найдвартай хангах, усыг тогтмол шинжилгээнд хамруулах</p> <p>Ундны усыг олборлохоос хэрэглэгч хүртлэх тогтолцооны зураглал гаргах, ундны усыг бохирдуулж болох эрсдэлд үнэлгээ хийх, сайжруулах болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах</p> <p>Онцгой байдал болон гамшгийн үед цэцэрлэгийг аюулгүй усаар хангах гамшиг, ноцтой байдлын үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах</p> <p>Усны эх үүсвэрийн харуул, хамгаалалтыг өндөржүүлэх, гэмт халдлагаас хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p>	
9	Төрийн байгууллага бус	<p>УАБТ-ний хэрэгжилтэнд хяналт тавих, мэдээлэл, сургалт сурталчилгааны ажилд хамтран ажиллах</p>	
10	Иргэн	<p>Хүн амыг цэвэр, аюулгүй усаар хангаж байгаад хяналт тавих, санал хүсэлтийг багт тавьж шийдвэрлүүлэх, УАБТ боловсруулахад оролцох, иргэдийг үнэн зөв мэдээллээр хангах</p>	

АЛХАМ 2. ГАЗРЫН ЗУРАГ, УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛ



Тайлбар:  - гэр хороолол

АЛХАМ 2. УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ ЗУРАГЛАЛЫГ ГАРГАХАД
АШИГЛАХ МЭДЭЭЛЭЛ

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Судалгаа авсан он, сар, өдөр: _____

2. Аймаг, сумын нэр: _____

Байгууллагын нэр: _____

3. Үйлчлэх хүрээний хүн амын тоо: _____

4. Ундны усны эх үүсвэр:

Гүний худаг

Гар худаг

Булгийн ус

Гадаргын ус /гол, нуур, цөөрөм г.м/

Бусад /бичнэ үү/ _____

5. Олборлон түгээж буй усны хэмжээ? [м3/жил] _____

[м3/хоног] _____

6. Усны нөөц эх үүсвэр байгаа юу?

Тийм

Үгүй

Хэрэв байгаа бол тодорхой бичнэ үү ?

2. УС ХАНГАМЖИЙН МЕНЕЖМЕНТ

1. Ус хангамжид орон нутгийн иргэдийн оролцоо байдаг уу?

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол орон нутгийн иргэдээс үүнийг хариуцаж ажилладаг баг байгуулсан уу?

Тийм

Үгүй

Хэрэв үгүй бол ус хангамжийн үйл ажиллагаа болон удирдлагыг хэн эсвэл ямар байгууллага хариуцаж ажилладаг вэ?

2. Ус хангамжийн үйл ажиллагаа болон удирдлагыг хариуцаж ажилладаг орон нутгийн иргэд болон гишүүдийн тоо хэд вэ?

3. Ус хангамжийн үйл ажиллагаа болон удирдлагыг хэн хариуцан ажилладаг вэ?

Нэр: _____

Тодорхой үүрэг: _____

Мэргэжил: _____

Нэр: _____

Тодорхой үүрэг: _____

Мэргэжил: _____

4. Ус хангамжийн байгууллага эсвэл орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай холбогдох хүн хэн вэ?

Нэр: _____

Холбоо барих мэдээллүүд: _____

Нэр: _____

Холбоо барих мэдээллүүд:

5. Ус хангамжийн үйлчилгээнд орон нутгийн иргэдээс төлбөр авдаг уу?

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол 1 л усны үнэ: _____

3. УС ХАНГАМЖИЙН ТАСРАЛТГҮЙ БАЙДАЛ

1. Ус хангамжийн байгууллага нь үйлчлүүлэгчдийг хэрхэн усаар хангадаг вэ?

Тасралтгүй

Завсарлагатайгаар

2. Завсарлагатайгаар бол өдөрт _____ цаг, долоо хоногт _____ өдөр усаар хангадаг.

3. Усны хүрэлцээ хангалттай юу?

Хүрэлцээтэй

Улирлаас хамааралтай хүрэлцээгүй

Хүрэлцээгүй

4. УС ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦООНЫ БҮРЭЛДЭХҮҮН ХЭСГИЙН МЭДЭЭЛЭЛ

А. Ус олборлох

1. Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага эсвэл хяналтын байгууллагад усны эх үүсвэрийн нянгийн болон химийн чанарын талаарх мэдээлэл байдаг уу?

Тийм

Үгүй

Хэрэв тийм бол усны чанарын талаар тодорхой бичнэ үү

2. Цаг уурын улираллаг байдал усны чанарт нөлөөлдөг эсэх?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү

3. Хэрэв гүний ус хэрэглэдэг бол тухайн бүс дэх гүний усны урсгал, чиглэлийн талаарх мэдээлэл байдаг уу?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол гүний усны урсгалыг тэмдэглэнэ үү

- Хойд
 Өмнөд
 Баруун
 Зүүн

4. Ундны усны эх үүсвэрийн цэгийн тоо: _____

5. Усаа яаж олборлодог вэ?

- Гараар
 Гар насосоор
 Цахилгаан насосоор

6. Усны байгалийн химийн найрлагын талаар шинжилгээ, нотолгоо байдаг эсэх?

- Төмөр
 Манган
 Хүнцэл
 Фтор
 Бусад _____

7. Ундны усны эх үүсвэрийн эргэн тойронд бохирдуулж болох эх үүсвэр ба хоорондын зайг бичнэ үү?

- Хамгийн ойр байх ариун цэврийн байгууламж(бие засах газар, бохирын цооног),км
- Төвлөрсөн бохир усны шугам хоолой,км
- Хөдөө аж ахуй болон цэцэрлэгжилтийн үйл ажиллагаа:
- Малын хашаакм
 - Хөдөө аж ахуйн үйлдвэр,км
 - Бордоо ашигладаг,км
 - Пестицид ашигладаг,км
 - Усалгаа/ус зайлуулах хоолой.....км
- Машин угаалгын болон засварын газар, мал нядалгааны газар.....км

- Уул уурхайн үйлдвэр,км
- Түлшний агуулах,км
- Хог хаягдлын нэгдсэн цэгкм
- Бусад _____
- Мэдээлэл байхгүй

8. Ундны усны эх үүсвэрийн орчимд амьдарч, ажиллаж буй хүмүүстэй уулзаж, ундны усны чанарт тэдний үйл ажиллагаа нөлөөлж болох талаар ярилцлага хийдэг үү?

- Тийм
- Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү ? /хэнтэй, ямар давтамжтай/

9. Усны эх үүсвэрийн эргэн тойронд усыг бохирдуулагч байгаа эсэхэд хяналт хийдэг үү?

- Тийм
- Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү \хэн шалгадаг, ямар давтамжтай\

Б. Боловсруулах

1. Усны эх үүсвэрийн усыг боловсруулдаг уу?

- Тийм
- Үгүй

Хэрэв үгүй бол "Нөөцлөх буюу В" хэсэг рүү очно уу.

2. Ямар төрлийн боловсруулалт хийгддэг вэ?

- Тунгаах
- Шүүх
- Халдваргүйжүүлэх
- Бусад /бичнэ үү/ _____

Цэвэршүүлэлтэнд хэрэглэж буй тоног төхөөрөмж, химийн бодисын талаар мэдээллийг бичнэ үү

3. Хэрэв ундны усыг хлороор халдваргүйжүүлдэг бол хлоржуулалтыг яаж хийдэг талаар тодорхой бичнэ үү? /бүтээгдэхүүний тодорхойлолт, тунлаж буй журам, ундны усанд дахь үлдэгдэл хлорын хэмжээ, хлоржуулалтыг тасралтгүй хийдэг үү эсвэл тодорхой нөхцөл үүсэн үед хийдэг эсэх ...г.м/

4. Боловсруулах, халдваргүйжүүлэх төхөөрөмж хэдэн онд суурилагдсан бэ?

Төхөөрөмжийг тавьснаас хойш техникийн шинэчлэл хийгдсэн үү?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү? /он, юу хийсэн/ _____

5. Одоо төхөөрөмж нь ажиллаж байгаа юу?

- Тийм
 Үгүй

Хэрэв үгүй бол шалтгааныг тодорхой бичнэ үү? _____

6. Танд доорх асуудлууд тулгарч байсан уу?

- Хүчин чадал нь бага
 Эрчим хүчний тасалдалт
 Боловсруулах технологи усны чанарт тохирдоггүй
 Боловсруулалт, халдваргүйжүүлэлтээс усны эх үүсвэрийн чанар өөрчлөгдсөн
 Төхөөрөмж нь эвдэрдэг
 Халдваргүйжүүлэлтийн бодисын олдоц муу
 Шаардагдах химийн бодисын туналалт хангалтгүй
 Химийн бодис ашиглаж хийж буй ажилчдад зориулсан хувийн хамгаалах хэрэгсэл байхгүй
 Бусад _____

7. Боловсруулах, халдваргүйжүүлэх үйл ажиллагааг хянадаг уу? /булинггар, үлдэгдэл хлорын хэмжээ/

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү /хяналтын үзүүлэлтүүд, зорилтот түвшин, давтамж ... гм/

8. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийдэг үү?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү \хэр давтамжтай, аль хэсэг дээр нь\

В. Нөөцлөх

1. Ундны усаа нөөцөлдөг уу?

- Тийм
 Үгүй

Хэрэв үгүй бол "Түгээх буюу Г" хэсэг рүү очно уу.

2. Хэдэн усан сан /ёмкость/-тай вэ? _____

3. Усан сангийн хэмжээ /хэрэв хэд хэдэн усан сантай бол тэдний тус бүрээр бичнэ үү/

4. Усан сангийн насжилт? /хэрэв хэд хэдэн нөөцлөх савтай бол тус бүрээр бичнэ үү/

5. Усан санг ямар материалаар хийсэн бэ? /хэрэв хэд хэдэн нөөцлөх савтай бол тус бүрээр нь бичнэ үү/ _____
6. Усан сангийн бүрэн бүтэн байдлыг ямар давтамжтай шалгадаг вэ?

7. Усан санг ямар давтамжтайгаар цэвэрлэж угаадаг вэ?

8. Усан санд дараах асуудлууд тулгардаг уу?
- Усан сангийн хийц гэмтсэн
 - Хяналтын хаалт (хавхлага) байхгүй, эвдэрсэн, зэвэрсэн
 - Агааржуулалтын хоолой нь хаалтгүй, эвдэрсэн
 - Усан сан нь бохир
 - Цэвэрлэгээ, үйлчилгээ шаардлага хангадаггүй
 - Бусад _____

9. Гарсан дутагдалуудыг засах боломжтой юу?

- Тийм
- Үгүй

Хэрэв үгүй бол, яагаад?

Г. Түгээх

1. Усыг түгээлтийн шугам хоолойгоор түгээдэг ?

- Тийм
- Үгүй

Хэрэв үгүй бол "Цуглуулах, хэрэглэх буюу Д" хэсэг рүү очно уу.

2. Түгээлтийн шугам хоолойн холболт:

- Ус түгээх байр

Хэрэв дугуйлсан бол хэдэн ус түгээх байртай вэ? _____

- Айлуудыг шугам сүлжээнд холбосон

Хэрэв дугуйлсан бол айл өрхийн хэдэн хувь нь холбогдсон бэ? _____

3. Түгээлтийн шугам хоолойн насжилт /анх хэдэн онд суурилуулсан/? _____

4. Түгээлтийн шугам хоолойн урт хэд вэ? _____

5. Түгээлтийн шугам хоолойд засвар үйлчилгээ хангалттай хийгддэг үү?

- Тийм
- Үгүй

Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү /засвар үйлчилгээг хэзээ, хэрхэн хийж гүйцэтгэсэн, өртөг/

6. Түгээлтийн шугам хоолойны материал: _____

7. Түгээлтийн шугам хоолойг хянаж шалгадаг уу?

8. Шугам хоолойтой холбоотой доорх асуудлууд тулгарч байсан уу? /давтамж, шалтгааныг /

- Гэмтэл
- Даралт багасах
- Усны зориулалтын бус шугам хоолой холбох
- Шугам хоолойг газрын гадарга дээр ил гарах
- Шугам хоолой зэврэх
- Бусад /

9. Гарсан дутагдалуудыг засах боломжтой юу?

- Тийм
- Үгүй

Хэрэв үгүй бол, яагаад? _____

Д.Цуглуулах, хэрэглэх

1. Усыг юунд ашигладаг вэ?

- Унданд
- Хувийн ариун цэвэр сахих
- Хоол хүнс бэлтгэх
- Цэвэрлэгээ
- Усалгаа
- Амьтан тэжээх
- Бусад _____

2. Хичнээн ус түгээх байрнаас усаа авдаг вэ? _____

3. Ус түгээх байрыг хариуцагч байдаг уу?

- Тийм
- Үгүй

Тийм бол тэдний үүрэг юу вэ? _____

4. Усаа авахын тулд хэр хол, ямар хугацаа зарцуулдаг вэ?

- Ус авах давтамж /7 хоногт/ _____
- Нэг удаа ирж очих зай /метр/ _____
- Нэг удаа ирж очих хугацаа /минут/ _____
- Нэг удаа авах усны хэмжээ /литр/ _____

5. Өөр усны эх үүсвэр танайд байдаг уу?

- Тийм
 Үгүй

Хэрэв байдаг бол ямар зорилгоор ямар ус хаанаас авдгаа бичнэ үү?

6. Усаа хадгалдаг уу?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол ус хадгалдаг савны талаар бичнэ үү _____

7. Усаа цэвэршүүлдэг(боловсруулах) үү?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол цэвэршүүлэгчийн талаар тодорхой бичнэ үү /буцалгах, шүүх, халдваргүйжүүлэх/ _____

8. Эрүүл ахуйн боловсрол, мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хөтөлбөр байдаг уу?

- Тийм
 Үгүй

Тийм бол тодорхой бичнэ үү \хөтөлбөрийн хангалт, хүн амын хамрах хүрээ, хөтөлбөрийн агуулга, сургалтын материал г.м\

5. УСНЫ ЧАНАРЫН ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ

1. Ундны усны чанарын хяналтыг ямар байгууллага, хэр давтамжтай хийдэг вэ?

2. Ундны усанд нян, хими болон физикийн үзүүлэлтээр шинжилгээ хийдэг үү?

3. Ундны усны дээжийг хаанаас авдаг вэ? /эх үүсвэр, ус түгээх байр, ус нөөцлөх сав, ус хадгалах сав ... гм/

4. Ундны усны чанарыг өрхийн түвшинд хянадаг байгууллага байгаа юу?

- Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү \ямар давтамжтай, хир хугацаанд г.м\

5. Ундны усны шинжилгээний хариуг олон нийтэд мэдээлдэг үү?

- Үргэлж

Заримдаа
 Үгүй

6. Усны чанартай холбоотой асуудал гарч байсан уу?

Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү _____

7. Ундны усны чанарыг өөр байгууллага хариуцаж хяналт тавьдаг уу ?

Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү? /ямар үзүүлэлтээр, ямар хугацаатайгаар/

8. Ундны усны чанартай холбоотой зарим асуудлаар олон нийтээс гомдол гардаг уу?

Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү /ямар асуудлаар, ямар давтамжтай, хэрхэн тайлагнадаг ... гм\ _____

9. Олон нийтэд устай холбоотой өвчний талаар мэдээлэл өгдөг үү?

Тийм
 Үгүй

Хэрэв тийм бол тодорхой бичнэ үү /ямар өвчнүүд, ямар давтамжтай, хэдэн хүн хамрагдсан, өртсөн газар зүйн бүс, өртсөн хүмүүс ... гм/

10. Сүүлийн 5 жилийн хугацаанд хийгдсэн ундны усны чанарын хяналтын талаар мэдээлэл өгнө үү?

АЛХАМ 3. АЮУЛТ ХҮЧИН ЗҮЙЛ, ҮЗЭГДЭЛ, ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ

ХЯНАЛТЫН ХУУДАС

Нэг. ЭХ ҮҮСВЭРИЙН ХУДАГ

1. Ерөнхий мэдээлэл

1. Аймаг, сумын нэр _____
2. Эзэмшигчийн нэр, худгийн дугаар, байршил

3. Үйлчлэх хүрээний хүн амын тоо _____
4. Хяналт хийсэн он сар өдөр _____
5. Хяналт хийх үеийн цаг агаарын байдал _____

2. Үнэлгээний онцлог асуултууд

1. Худгийн эргэн тойрон 50 метрийн зай дотор ариун цэврийн байгууламж, бохирын цооног байдаг уу?
 Тийм Үгүй
2. Хашаа байхгүй, хангалтгүй буюу эвдэрсэн, гүний худагт 100 метрт хамгаалалтын бүс тогтоосон уу?
 Тийм Үгүй
3. Гар худгаас 10, гүний худгаас 50 метрийн зай дотор амьтад орох боломжтой, өөр бохирдуулагч эх үүсвэрүүд байдаг уу?
 Тийм Үгүй
4. Гар худгаас 3, гүний худгаас 2 метрийн зай дотор ус тогтонгишсон уу?
 Тийм Үгүй
5. Ус татах хоолой байхгүй эсвэл насос эвдэрсэн, засварлах хэрэгтэй юу?
 Тийм Үгүй
6. Ус өгөх хоолой байдаггүй, эвдэрсэн болон цэвэрлэх хэрэгтэй юу?
 Тийм Үгүй
7. Худгийн эргэн тойронд 2 метрээс багагүй талбайг цементлэж эсвэл хавтанжуулсан уу?
 Тийм Үгүй
8. Цементлэсэн болон хавтанжуулсан талбайд цууралт үүссэн үү?
 Тийм Үгүй
9. Эх үүсвэр /гүний худаг/-ийн байшин, барилга эрүүл ахуйн шаардлага хангасан уу?
 Тийм Үгүй
10. Эх үүсвэр /гүний худаг/-ийн таглаа, насос, ус татдаг олс байдаггүй, эвдэрсэн, бохир байдаг уу?
 Тийм Үгүй

3. Үр дүн ба зөвлөмж

Хяналтын эрсдэлийн оноо

- Маш их эрсдэлтэй /8-аас их оноо/
- Их эрсдэлтэй /5-8 оноо/
- Дунд эрсдэлтэй /3-5 оноо/
- Бага эрсдэлтэй /0-3 оноо/

Энэ хуудсыг өөрчлөх эрсдэлийн чухал хэсгүүдийг тэмдэглэж мэдээлсэн:

- 1-10 хариултыг эрэмбэлэх
- Нэмэлт зөвлөмжүүд

Эрсдэлийн тооцоог хийсэн хүний нэр гарын үсэг: _____

Хоёр. УСАН САН

1. Ерөнхий мэдээлэл

1. Аймаг, сумын нэр _____
2. Байршил _____
3. Хяналт хийсэн он сар өдөр _____
4. Хяналт хийх үеийн цаг агаарын байдал _____

2. Үнэлгээний онцлог асуултууд

1. Усан сан лацтай, харуул хамгаалалттай юу?
 Тийм Үгүй
2. Дамжуулах, түгээх шугам хоолойгоос ус шүүрдэг үү?
 Тийм Үгүй
3. Усан сангийн хийц эвдэрч, цуурсан уу?
 Тийм Үгүй
4. Усан сангийн хяналтын хаалт (хавхлага)байхгүй,эвдэрсэн, зэвэрсэн эсвэл онгорхой байдаг уу?
 Тийм Үгүй
5. Усан сан эрүүл ахуйн хамгаалалтын бүстэй юу?
 Тийм Үгүй
6. Усан сан нь юүлэх хоолойтой юу?
 Тийм Үгүй
7. Усан сангийн хяналтын хаалт бохир уу?
 Тийм Үгүй
8. Усан сангийн агааржуулалтын хоолойд тор байдаггүй эсвэл эвдэрсэн үү?
 Тийм Үгүй
9. Усан санд ямар нэг хаягдал, гадны биет орох боломжтой юу?
 Тийм Үгүй
10. Усан санг тойрсон хамгаалалтын хашаа байдаггүй, хашаа нь эвдэрсэн, амьтад нэвтрэх эрсдэлтэй юу?
 Тийм Үгүй

3. Үр дүн ба зөвлөмж

Хяналтын эрсдэлийн оноо

- Маш их эрсдэлтэй /8-аас их оноо/
- Их эрсдэлтэй /5-8 оноо/
- Дунд эрсдэлтэй /3-5 оноо/
- Бага эрсдэлтэй /0-3 оноо/

Энэ хуудсыг өөрчлөх эрсдэлийн чухал хэсгүүдийг тэмдэглэж мэдээлсэн:

- 1-10 хариултыг эрэмбэлэх
- Нэмэлт зөвлөмжүүд

Эрсдэлийн тооцоог хийсэн хүний нэр гарын үсэг: _____

Гурав. ТҮГЭЭХ

1. Ерөнхий мэдээлэл

1. Аймаг, сумын нэр _____
2. Ус түгээлтийн системийн төрөл, байршил _____
3. Хяналт хийсэн он сар өдөр _____
4. Хяналт хийх үеийн цаг агаарын байдал _____

2. Үнэлгээний онцлог асуултууд

1. Байнгын цорго болон шланкны бүрэн бүтэн байдал алдагдсан уу?
 Тийм Үгүй
2. Байнгын цорго болон шланк нь эрүүл ахуйн шаардлага хангадаг уу?
 Тийм Үгүй
3. Байнгын цорго болон шланкыг бохирдохоос хамгаалдаг уу?
 Тийм Үгүй
4. Ус өгөх шланк, машины хоолойг залгаж, салгах боломжтой юу?
 Тийм Үгүй
5. Ус өгөх шланкыг оруулж, гаргах нүхийг битүүмжилдэг үү?
 Тийм Үгүй
6. Ус өгөх шланк дах үлдэгдэл усыг шавхдаг уу?
 Тийм Үгүй
7. Усны машинд өгөх хэсэг болон ус буулгах хоолойг тогтмол тагладаг уу?
 Тийм Үгүй
8. Хэрэглэгчид сүүлийн 7 хоногт түгээлттэй холбоотой гомдол гарсан уу?
 Тийм Үгүй
9. Сүүлийн 10 хоногт ус түгээлтэд тасралт гарсан уу?
 Тийм Үгүй
10. Усны машины ус юүлэх хоолойг ил задгай нугалж явдаг уу?
 Тийм Үгүй

3. Үр дүн ба зөвлөмж

Хяналтын эрсдэлийн оноо

- Маш их эрсдэлтэй /8-аас их оноо/
- Их эрсдэлтэй /5-8 оноо/
- Дунд эрсдэлтэй /3-5 оноо/
- Бага эрсдэлтэй /0-3 оноо/

Энэ хуудсыг өөрчлөх эрсдэлийн чухал хэсгүүдийг тэмдэглэж мэдээлсэн:

- 1-10 хариултыг эрэмбэлэх
- Нэмэлт зөвлөмжүүд

Эрсдэлийн тооцоог хийсэн хүний нэр гарын үсэг: _____

Дөрөв. ГЭРИЙН НӨХЦӨЛД УСЫГ ХАДГАЛАХ

1. Ерөнхий мэдээлэл

2. Аймаг, сумын нэр _____
3. Ус авдаг усны эх үүсвэрийн төрөл, байршил _____
4. Байгууллагын нэр _____
5. Хяналт хийсэн он сар өдөр _____

2. Үнэлгээний онцлог асуултууд

1. Нэгээс илүү эх үүсвэрээс усаа авдаг уу?
 Тийм Үгүй
2. Ундны ус зөөдөг болон хадгалдаг сав тусдаа юу?
 Тийм Үгүй
3. Ундны ус зөөх, хадгалах сав нь зориулалтын сав мөн үү?
 Тийм Үгүй
4. Ундны ус зөөдөг болон хадгалдаг савыг тогтмол угааж, цэвэрлэдэг үү?
 Тийм Үгүй
5. Ундны ус зөөдөг болон хадгалдаг сав нь цуурч ус шүүрдэг үү?
 Тийм Үгүй
6. Ундны ус зөөдөг болон хадгалдаг савыг өөр бусад зүйлийг хийхэд ашигладаг уу?
 Тийм Үгүй
7. Ундны ус зөөдөг, хадгалдаг саванд таглаа байхгүй юу?
 Тийм Үгүй
8. Ундны ус хадгалдаг сав нь шууд газарт байрладаг уу?
 Тийм Үгүй
9. Ундны ус хадгалдаг савны эргэн тойрон бохир уу?
 Тийм Үгүй
10. Ундны ус хадгалдаг саванд мал, амьтан хүрэх боломжтой юу?
 Тийм Үгүй

3. Үр дүн ба зөвлөмж

Хяналтын эрсдэлийн оноо

- Маш их эрсдэлтэй /8-аас их оноо/
- Их эрсдэлтэй /5-8 оноо/
- Дунд эрсдэлтэй /3-5 оноо/
- Бага эрсдэлтэй /0-3 оноо/

Энэ хуудсыг өөрчлөх эрсдэлийн чухал хэсгүүдийг тэмдэглэж мэдээлсэн:

- 1-10 хариултыг эрэмбэлэх
- Нэмэлт зөвлөмжүүд

Эрсдэлийн тооцоог хийсэн хүний нэр гарын үсэг: _____

АЛХАМ 4. ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭН ЭРЭМБЭЛЖ, САЙЖРУУЛАХ АРГА ЗАМЫГ ТОДОРХОЙЛОХ

ЮуЛТ ҮЧИН ЗҮЙЛ	Аюулт үзэгдэл	Эрсдэлийн зэрэг	Сайжруулах арга зам
/с хангамжийн эх үүсвэрийн худаг			
ИОЛОГИ	1.Хамгаалалтын бүс тогтоож тэмдэгжүүлээгүй	Өндөр	1.Ундны ус хангамжийн эх үүсвэрийн газрыг баталгаажуулах 2.Энгийн бүсийг эх үүсвэрийн худагас 300 метрт тогтоож тэмдэгжүүлэх 3.Ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн болон энгийн хамгаалалтын бүс тогтоосон захирамж гаргаж баталгаажуулах 4.Гүний худаг тус бүрийг хашаажуулах
РИЗИК	2.Эрчим хүчний тасалдалт	Бага	5.Эрчим хүчний нөөц эх үүсвэртэй болох
ИОЛОГИ	3.Усан санд халдваргүйжүүлэлт хийгддэггүй	Өндөр	6.Усан санд угаалга, халдваргүйжүүлэлт хийх заавартай болох
ИОЛОГИ, ХИМИ	4.Ус цэвэршүүлэх засвар, үйлчилгээ хийдэггүй	Өндөр	7.Ус цэвэршүүлэх төхөөрөмжийн талаар худгийн ажилтан, холбогдох мэргэжлийн хүмүүсийг сургаж, цэвэршүүлэх төхөөрөмжид үйлчилгээ хийх заавартай болох
ИОЛОГИ	5.Худгийн эргэн тойрныг цементлээгүй, асгарсан усны тогтоол бий болсон	Өндөр	8.Худгийн эргэн тойрныг цементлэх
ХИМИ	6.Уурын зуухны дэргэд худаг байрласан	Өндөр	9.Унданд хэрэглэхгүй байх
Физик	7.Ундны усны нөөц шинэчлэн тогтоогоогүй	Дунд	10.Усны нөөцийг шинэчлэн тогтоох
ИОЛОГИ, ХИМИ	8.Үерийн далан суваг байгуулаагүй	Дунд	11.Үерийн далан суваг барьж байгуулах ажлыг мэргэжлийн байгууллагаар хийлгэх
Физик	9.Элсний нүүдэл	Өндөр	12.Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн гадна талаар мод тарих
ИОЛОГИ, ХИМИ	10.Нян судлалын үзүүлэлтээр шинжилгээ хийлгүүлдэггүй	Өндөр	13.Улирал тутам нян судлалын шинжилгээнд хамруулах

Хими	11. Бор /В/, төмөр, Селени стандарт хэмжээнээс их	Өндөр	14. Химийн хорт бодисыг шүүх төхөөрөмж суурилуулан ашиглалтыг хангаж ажиллах
Малчны гүн өрмийн худаг			
Юологи, хими	12. Худгийн цооногийн битүүмжлэл алдагдсан	Өндөр	15. Худгийн цооногийн битүүмжлэлийг хангаж лацтай болгох
Хими	13. Худгийн байшинд моторны утаа гардаг	Өндөр	16. Агааржуулалттай болгох
Юологи	14. Худгийн усан санд халдваргүйжүүлэлт хийгддэггүй	Өндөр	17. Усан санд угаалга, халдваргүйжүүлэлт хийх заавартай болох
Физик, хими	15. Усан сан таггүй	Өндөр	18. Усан санг тагтай болгох
Юологи, хими	16. Мал услах онгоцыг худагтай тулгаж байрлуулснаас шалбааг үүссэн	Өндөр	19. Онгоцыг эрүүл ахуйн хамгаалалтын бүсээс гаргаж, талбайг цементлэх
Юологи	17. Уурхайн болон гар худгууд ил задгай байрласан, битүүмжлэл, таггүй	Өндөр	20. Худгийг барилга, байшинтай болгож, цоож хийх
Юологи, хими	18. Гар худагт машины дугуйн хаймраар хийсэн ховоо ашигладаг	Өндөр	21. Худгийг лайдах, баг оврын цахилгаан болон гар нассостай болгох
Булаг			
Юологи	19. Булгийн ус бохирдох	Өндөр	22. Булгийн эхийг хамгаалах, тохижуулах
Ус түгээх байр			
Юологи	20. Ус түгээгчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулдаггүй	Дунд	23. Ус түгээгчийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулах
Юологи	21. Ус түгээх байрны ус өгөх шланк бохирдох	Өндөр	24. Ус өгөх шланкыг хэрэглээгүй нөхцөлд тоос шорооноос хамгаалсан цэвэрхэн хошуувч хийж 80 см - ээс доошгүй өндөрт өлгөж байх
Хэрэглэгч			
Хими, Юологи	22. Иргэдийн ус зөөдөг сав эрүүл ахуйн шаардлага хангахгүй	Бага	25. Иргэдэд зориулсан сургалт сурталчилгааны ажлыг нэмэгдүүлэх

АЛХАМ 4. ХҮН АМЫН УНДНЫ УСНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ САЙЖРУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ул, эрсдэл	Төлөвлөх		Хэрэгжүүлэх				Санхүүжилт /төгрөг/
	Үйл ажиллагаа	Сайжруулах арга зам	Байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Хугацаа		
1 хүрэлцээ, игүй байдал элтгүй	Малчдын ундны усны хангамж, хүрэлцээ аюулгүй сайжруулах	Богино, дунд, урт хугацааны төлөвлөгөө гарган, багуудад дэс дараатай ундны усны эх үүсвэр шинээр гаргаж, эрүүл ахуйн шаардлага хангуулах	Сумын Засаг дарга	Мэргэжлийн байгууллага	Жил бүр	70 сая	
ин худаг, огт мал, ан орох	Сумын төвийн ундны усны дэргэд байгаа хуучин худгийн цооногийг битүүмжлэх	Цооногийг битүүмжилж дарж булаах	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Мэргэжлийн байгууллага	2014 он	-	
л ахуйн аалалтын й, барилга ууламжгүй	Малчны гүн өрмийн, уурхайн, гар худгийг хамгаалах, ус түгээх байрууд, инженерийн тоног төхөөрөмжтэй худагтай болох	Эрүүл ахуйн бус тогтоож хамгаалалт хийж тохижуулах	Сум, багийн Засаг дарга	Худаг эзэмшигч иргэд	2015-2016 он	1 худагт 2 сая	
/сны үзэгдэл	Үерийн далан суваг хийх	Үерийн далангийн зургийн дагуу хийнэ	Сум, багийн засаг дарга	Мэргэжлийн байгууллага Худаг эзэмшигч иргэд	2014-2016	1 худагт 4 сая	
			Сумын засаг дарга	Худаг эзэмшигч иргэд	2015-2016 он	1 худагт 300 мянга	

д) хомсдол	БОНХАЖЯ-аар ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээг тогтоолгох	Сумын усны нөөц, судалгааг гаргах	Сумын Засаг дарга, Байгаль орчны хяналтын улсын байцаагч	ХАА-н үржлийн тасаг Багийн Засаг дарга	2014 он	Улсын болон орон нутгийн төсөвт тусгах
е) эх үүсвэр алийн лигт өртөх	Гамшгийн төлөвлөгөө боловсруулах	Гамшгийн хэрэгжүүлэх төлөвлөгөөг	Байгаль орчны хяналтын улсын байцаагч	Мэргэжлийн байгууллага	2014 он	-
ж) сан, усны машины савыг рлэх, варгүйжүү- зааваргүй	Усан сан, усны машины савыг цэвэрлэх, халдваргүйжүүлэх заавартай болох	Холбогдох үндэслэн боловсруулж хэрэгжүүлэх зөвлөмжийг зааврыг	Ус хангагч байгууллага	Мэргэжлийн халдваргүйжүүл элтийн байгууллага	2013 он	-
з) түгээх уурадад ржуулалтгүй	Ус түгээх байруудад агааржуулалт хийх	Энгийн агааржуулалтын систем суурилуулах	Ус хангагч байгууллага	Мэргэжлийн байгууллага	2014 он	150 мянга
и) сангийн ус н сагддаггүй	Усан сангийн ус бүрэн шавхагддаг болгох	Усан сангийн ёроолд крант байршуулах	Ус хангагч байгууллага	Мэргэжлийн байгууллага	2013	500 мянга
л) байрны өл элтгүй	Ус түгээгчдийг ажлын байрны хувцасаар хангах	Ус түгээх байрны дулаан 12 градусаас хэтэрдэггүй тул дулаан хувцасаар хангах	Ус хангагч байгууллага		2013	
м) ермийн г уст цэгийн элэл дутуу	Худаг, уст цэгүүдийг паспортжуулах	Сум, багийн төвүүдийн гүн өрмийн хурднуудыг паспортжуулах	Сумын болон багуудийн засаг дарга, мэргэжлийн байгууллага		2014-2016 он	200 мянга

<p>ы ус, түүний лээ, ус эрлөх, злах савны ар лэгчдийн лэг дутмаг</p>	<p>Зориулалтын усны сав сонгож авах, тогтмол угааж хэрэглэх</p>	<p>Ус хангагч байгууллага нь өөрийн ажилчдад болон үйлчлүүлэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөр боловсруулж сурталчлах Албан байгууллага, иргэд, гал тогоо бүхий газруудыг хамруулах</p>	<p>Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн төв</p>	<p>Төрийн бус байгууллага, олон нийт, иргэд</p>	<p>ТОГТМОЛ</p>	<p>3 сая</p>
--	---	---	---	---	----------------	--------------

АЛХАМ 5. ХЯНАЛТ - ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Д/д	Хийх ажил	Байгууллага	Хугацаа	Цаашид авах арга зам
1	Сумын төвийн ус хангамжийн эх үүсвэр болон ус түгээх цэгээс дээж авч шинжилгээнд хамруулах	Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, байгаль орчны хяналтын улсын байцаагч	Графикийн дагуу сар бүр тогтмол	Сумын засаг даргын баталсан графикийн дагуу хамтарсан хяналт шинжилгээ хийсэн дүнг сумын Засаг даргын Тамгын газарт танилцуулах
2	Сумын усны аюулгүй байдлын төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавих	Сумын усны аюулгүй төлөвлөгөө боловсруулах багийн гишүүд	Багийн дарга гишүүдийн ажлын хуваарийн дагуу улирал бүр тогтмол хийх	Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний биелэлтийг ИТХ-ын тэргүүлэгчдийн тогтоолд заасан хугацаанд хэлэлцэн дүнг Засаг даргад танилцуулан холбогдох арга хэмжээг авах
3	Сум, багуудын хүн амд хэрэглэж буй ундны усанд хяналт шинжилгээ хийх	Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч, байгаль орчны хяналтын улсын байцаагч	Графикийн дагуу улирал бүр тогтмол хийх	Сумын Засаг даргын баталсан хуваарийн дагуу хамтран хийсэн хяналт шинжилгээний дүнг сумын засаг даргын тамгын газарт танилцуулах
4	Аймгийн байгаль орчны алба, мэргэжлийн хяналтын газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг хяналтын байгууллагаар хяналт шинжилгээг хийлгэх	Сумын засаг даргын тамгын газар	Жил бүр тодорхой хугацаанд	Хяналт шинжилгээг хийлгэсэн тухай дүгнэлт, зөвлөмжийг үндэслэн холбогдох арга хэмжээг авах
5	Сумын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын ус ашиглалт хамгаалалт аюулгүй байдалд хяналт хийх	Сумын Засаг даргын Тамгын газар, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч	Жил бүр тодорхой графикийн дагуу	Сумын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын болон бусад чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын усны чанар аюулгүй байдлын талаар дүгнэлт, мэдээлэл гаргаж холбогдох арга хэмжээг авах

АЛХАМ 5. СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА АВАХ АСУУЛГА

Асуулгын дугаар :

Судлаачийн код :

Хүндэт хэрэглэгчид ээ!

Бид таниас усны хэрэглээ, түүнтэй холбоотой хэдэн асуулт асуухыг хүсэж байна. Энэхүү судалгааны үр дүнг бид цаашид үйл ажиллагаагаа сайжруулах, улмаар хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг дээшлүүлэхэд ашиглах юм. Тиймээс та бидний асуултанд чин сэтгэлээсээ хариулж, бидний ажилд туслалцаа үзүүлнэ гэж итгэж байна.

Таны оршин суугаа хаяг:

Дүүрэг:	/...../
Хороо:	/...../
Гудамжны нэр, дугаар:	/...../
Хаалганы дугаар:	/...../

1. Ус түгээх байрнаас хэдэн м зайд байрладаг вэ?

/...../ М

2. Ус авахад 2 талдаа хэр их хугацаа зарцуулдаг вэ?

1. < 15 мин
2. 15-30 мин
3. 30-45 мин
4. 45-60 мин
5. 60 мин-с илүү
6. Мэдэхгүй

3. Ус авдаг давтамж / өдөрт хэдэн удаа, хэдэн литр ус авдаг болох /

1. Удаа литр**БАЙГУУЛЛАГЫН ТАЛААРХ ОЙЛГОЛТ**

4. Цэвэр усаар хангах үйлчилгээг ямар байгууллага явуулдаг вэ?

5. Ус хангагч байгууллагын талаар урьд нь сонсож байсан уу ?

- | | |
|---|------|
| 1 | Тийм |
| 2 | Үгүй |

6. Хэрэв мэддэг бол ямар үйл ажиллагаа явуулдаг вэ?

(Олон сонголттой)

- | | |
|---|---|
| 1 | Хог хаягдал цэвэрлэдэг |
| 2 | Бохир ус зайлуулж, цэвэрлэдэг |
| 3 | Орон сууц нийтийн аж ахуйн газартай адилхан |
| 4 | Цахилгааны төлбөр авдаг газар |

5	Цэвэр усаар хангадаг
6	Гэрэлтүүлэг, дулаан хариуцдаг газар
7	Ундны усанд хяналт тавьдаг газар
8	Бусад /...../

ЕРӨНХИЙ СЭТГЭЛ ХАНАМЖ

7. Ус хангагч байгууллагын үйл ажиллагаанд үнэлэлт өгнө үү?

(Зөвхөн нэг хариулт сонгоно)

5	Маш их сэтгэл хангалуун
4	Сэтгэл хангалуун
3	Дунд зэрэг
2	Сэтгэл хангалуун бус
1	Огт сэтгэл хангалуун бус

УС ТҮГЭЭХ БАЙРНЫ ТАЛААР

8. Танай ус авдаг ус түгээх байрны ус

1. Машинаар зөөж хийдэг
2. Төв шугамтай холбоотой

9. Танай ус авдаг ус түгээх байр цагтаа ажилладаг эсэх? (✓) гэж тэмдэглэнэ үү)

		Тийм	Үгүй
1	Цагтаа онгойдог	1	2
2	Цагтаа хаадаг	1	2
3	Цайны цагаа хэтрүүлдэг	1	2

10. Ус түгээх байрны үйлчилгээний талаарх дараах асуудлуудад хэр сэтгэл хангалуун байдаг вэ?

(Холбогдох үнэлгээний тоог дугуйлна уу, чухал гэж үзсэн үзүүлэлтээ (✓) гэж тэмдэглэнэ үү)

№	Үзүүлэлт	Бүрэн сэтгэл ханамжтай	Сэтгэл ханамжтай	Дунд зэрэг	Сэтгэл ханамжгүй	Огт сэтгэл ханамжгүй	Чухал гэж үзсэн үзүүлэлтээ тэмдэглэнэ үү (✓)
1	Уг түгээх байрны ажиллах цагийн хуваарьт	5	4	3	2	1	
2	Цагийн хуваарийн дагуу ажилладаг байдал	5	4	3	2	1	
3	Үйлчилгээний ажилчдын харилцааны соёлд	5	4	3	2	1	
4	Үйлчилгээний ажилчдын түргэн шуурхай байдал	5	4	3	2	1	
5	Усны тасалдалт, усны хүрэлцээ хангамж	5	4	3	2	1	
6	Ус түгээх байрны ачаалал, хүчин чадлын хүрэлцээ	5	4	3	2	1	

7	Ус түгээх байрны зохион байгуулалт, үйлчлүүлж буй хүмүүсийн соёл	5	4	3	2	1	
8	Ус түгээх байрны тоног төхөөрөмжтэй холбоотой хүндрэл бэрхшээл	5	4	3	2	1	
9	Ус түгээх байрны орчин нөхцөл	5	4	3	2	1	
10	Усны үнэ	5	4	3	2	1	
11	Бусад /...../	5	4	3	2	1	

11. Ус түгээх байрны үйл ажиллагааг сайжруулахын тулд шаардлагатай 3 санал хэлнэ үү

- 1/.....
 2/.....
 3/.....

БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТАЛААРХ СЭТГЭЛ ХАНАМЖ

12. Ундны усны чанарын талаарх дараах асуудлуудад та хэр сэтгэл ханамжтай байна вэ?

(Холбогдох үнэлгээний тоог дугуйлна уу, чухал гэж үзсэн үзүүлэлтээ (✓)гэж тэмдэглэнэ үү)

№	Үзүүлэлт	Бүрэн сэтгэл ханамжтай	Сэтгэл ханамжтай	Дунд зэрэг	Сэтгэл ханамжгүй	Огт сэтгэл ханамжгүй	Чухал гэж үзсэн үзүүлэлтээ тэмдэглэнэ үү (✓)
1	Зэвтэй ус гарах	5	4	3	2	1	
2	Усны амтны хувьд	5	4	3	2	1	
3	Усны тасалдалт	5	4	3	2	1	
4	Усны эрүүл ахуйн байдал	5	4	3	2	1	
5	Усны өнгө	5	4	3	2	1	
6	Ус тунадастай байх	5	4	3	2	1	
7	Бусад /...../	5	4	3	2	1	

САНАЛ ХҮСЭЛТ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ

13. Устай холбоотой ямар нэгэн санал гомдол гарахад хаана ханддаг вэ?

.....

14. Санал гомдлоо хэлэхдээ доорх аргуудын алийг нь түлхүү хэрэглэдэг вэ?

1	Утсаар ярьдаг
2	Биеэр очиж уулздаг
3	Интернэтээр ханддаг
4	Хэрхэн хандахаа мэдэхгүй
5	Бусад /...../

УСНЫ ХЭРЭГЛЭЭ, ХАНДЛАГА

15. Усны хэрэглээ, түүнтэй холбогдох дараах асуудлуудад та хэрхэн хандаж байна вэ?
(Мөр тус бүрт хариулна уу)

№	Хандлага	Санал нийлж байна	Санал нийлүүлэхгүй	Мэдэхгүй
1	Ундны усны эрүүл ахуйд итгэдэггүй	1	2	3
2	Мөнгөө төлж байгаа учир усаа хэмнэх эсэх нь бидний асуудал	1	2	3
3	Усны үнэ хэтэрхий үнэтэй	1	2	3
4	Усны хүрэлцээ хангамж муу	1	2	3
5	Ундны усны эх үүсвэр ховордож байгаа	1	2	3
6	Ус хэмнэх талаар хүүхдүүддээ хэлж зөвлөдөг	1	2	3
7	Уг түгээх байрны тоог нэмэгдүүлэх хэрэгтэй	1	2	3

16. Усны зөв хэрэглээ, хэмнэлтийн талаархи мэдээллийг хаанаас авдаг вэ?

(Олон сонголттой)

1	Телевиз	5	Веб сайт
2	FM, Радио	6	Сууц өмчлөгчдийн холбооны хурлаас
3	Сонин, сэтгүүл	7	Огт сонсож байгаагүй
4	Тараах материал, зурагт хуудас	8	Бусад /...../

17. Та ус хангагч байгууллагын website-ийг мэдэх үү?

1	Мэднэ → хэлнэ үү.	<input type="text"/>
2	Мэдэхгүй	<input type="text"/>

18. Та ус хангагч байгууллагын 24 цаг санал хүсэлт авдаг утсыг мэдэх үү?

1	Мэднэ → хэлнэ үү.	<input type="text"/>
2	Мэдэхгүй	<input type="text"/>

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

19. Таны нас /...../

20. Таны хүйс

1	Эрэгтэй
2	Эмэгтэй

21. Таны боловсрол

1	Дээд
2	Тусгай дунд
3	Бүрэн дунд
4	Бүрэн бус дунд
5	Бага ба боловсролгүй

22. Танай өрхийн ам бүлийн тоо /...../

Судалгаанд оролцож хамтран ажилласан таньд баярлалаа.

АЛХАМ 6. ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн чиглэл	Зорилго	Жишээ
Сургалт	Ажиллагсадыг УАБ болон тэдний үйл ажиллагаа үүнд хэрхэн нөлөөлж байгаа талаар ойлголттой болгох	УАБ-ын сургалт Ажлын байранд тавигдах шаардлага Ажилд анх ороход танилцуулах сургалтанд хамруулах Эрүүл ахуйн горим
Судалгаа	УАБ-ыг хангах, сайжруулах талаар шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх	Аюулт хүчин зүйлийн талаар ойлгох Бохирдлыг илрүүлэх илүү оновчтой шалгуур боловсруулах судалгаа
Тоног төхөөрөмжийн тохиргоо	Түгшүүрийн хязгаарын хяналт найдвартай, нарийвчлал сайтай байх баталгааг хангах	Тохиргоо хийх хуваарь Автомат тохиргоо бүхий тоног төхөөрөмж

Төлөвлөгөөнд тойм үнэлгээг хийх затварыг харуулав. Үүнд:

		Хэрхэн	
Хэн	Хэзээ	Юунд	Хэрхэн
УАБТ-ний баг	<ul style="list-style-type: none"> - Тогтмол хугацаанд (жилд 1-ээс доошгүй удаа гэх мэт) - Гамшиг, ноцтой байдал үүссэний дараа 	Алхам 1 Алхам 2 Алхам 3 Алхам 4 Алхам 5 Алхам 6	<ul style="list-style-type: none"> - Багийн бүрдүүлэлтэнд дүгнэлт хийх - Зураг диаграммыг шалгаж, шаардлагатай бол өөрчлөлт оруулах - Эрсдэлийг тодорхойлж, дахин үнэлэх - Сайжруулах төлөвлөгөөг шинэчлэх - Ноцтой нөхцөл байдал, гамшигын шалтгааныг тогтоож, тоймлон үнэлэх гэх мэт

Жижиг суурин газрын ус хангамжид 6 алхамаар усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ. Үүнд:

